

<https://doi.org/10.69561/mjac.v26i51.5241>

Article | Fasc.4

## Баримтат киногоор соёлын өвийг баримтжуулан уламжлуулах нь

Басанбаярын Буяаннэмэх 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,  
Улаанбаатар, Монгол Улс  
✉ buyanaa3438@gmail.com

**Хураангуй:** Захчины хуримын зан үйлийг дүрсэлсэн “Алтан тулга, мөнгөн тотго” баримтат киног судалгааны хэрэглэгдэхүүн болгон сонгож, соёлын биет бус өвийг баримтат киногоор дамжуулан баримтжуулах, хадгалан хамгаалах ач холбогдлыг шинжиллээ. Ингэснээр баримтат киног зөвхөн мэдээлэл дамжуулах хэрэгсэл төдий бус, харин соёлын өвийг бүртгэх, хадгалах визуал (аудиовизуал) баримт бичиг болох боломжтой гэж үзэж байна. Судалгааны үр дүнд уг баримтат кино нь захчины хуримын зан үйлийн бүтэц, бэлгэдэл, ёс горимыг бодит нөхцөлд нь баримтжуулсан угсаатны зүйн судалгааны чухал эх сурвалж болохын зэрэгцээ соёлын биет бус өвийг өвлүүлэн уламжлуулахад дэмжлэг үзүүлэх бодит боломжтойг харууллаа. Түүнчлэн угсаатны бүлгийн зан заншил, ёс уламжлалыг баримтат кино хэлбэрээр бүтээн туурвихад тухайн угсаатны талаар хийгдсэн өмнөх судалгаанууд онол, арга зүйн чухал суурь болдгийг тодруулж байна.

**Түлхүүр үгс:** захчин хурим, хуримын зан үйл, соёлын биет бус өв, баримтат кино

## Documenting and transmitting intangible cultural heritage through documentary film

Buyannemekh Basanbayar 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University  
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia  
✉ buyanaa3438@gmail.com

**Abstract:** This study examines the significance of documenting and safeguarding intangible cultural heritage through documentary film, using “Altan tulga, mungun totgo, which depicts the wedding rituals of the Zakhchin ethnic group, as the primary research material. The study regards documentary film not merely as a medium for transmitting information, but as a potential visual (audiovisual) document for recording and preserving cultural heritage. The findings demonstrate that the documentary serves as an important ethnographic source that documents the structure, symbolism, and ritual practices of Zakhchin wedding rituals within their authentic social context. Furthermore, the study



reveals that documentary film has tangible potential to support the intergenerational transmission of intangible cultural heritage. It also clarifies that prior scholarly research on specific ethnic groups constitutes a crucial theoretical and methodological foundation for the production of ethnographic documentary films.

**Keywords:** *zakhchin wedding, wedding ritual, intangible cultural heritage, documentary film*

### Оршил

Соёлын биет бус өв (СББӨ) гэж ард түмний билиг авьяас, мэдлэг туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болж, биет бусаар өвлөгдөн үеэс үед уламжлагдсан соёлын үнэт зүйлсийг хэлдэг. СББӨ бол анхдагч шинжтэй үзэгдэл бөгөөд соёлын өвийн бусад бүх төрөл зүйлийн сурвалж болдгоороо онцлог. СББӨ-д аливаа угсаатан, үндэстний зан үйл, ёс заншил, тоглоом наадгай, баяр ёслол, ардын уламжлалт эрдэм ухаан зэрэг хүний оюун санаа, ухаан бодол, авьяас чадварын илэрхийллүүдийг багтаан хамруулдаг (Юндэнбат 2024, 32). Орчин цагт СББӨ-ийг баримтат киногоор дамжуулан хадгалах, түгээн дэлгэрүүлэх шаардлага нэмэгдэж байна. Баримтат кино нь соёлын өвийг бодит орон зайд үйлдэл, үг хэл, зан үйлийн нарийн бүтэцтэй нь хадгалж үлдэх боломж олгодог визуал баримт бичиг болдог. БСШУС-ын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/759 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын “Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлагын айд Захчин хуримын ёс, зан үйлийг баталсан.

Монголчуудын хуримын ёслол нь угсаатны соёлын онцлог, ёс суртахууны үнэт зүйлийг хадгалж ирсэн чухал өв юм. Хуримлах ёслол нь үндсэндээ гэрлэлтийг ардын ёс суртахуун, зан заншил, гоо сайхны сэтгэлгээ, эдийн засаг, хууль эрхийн харилцааны үүднээс хүндэтгэн баталж амьдралаа холбож буй хос хоёрын ирээдүйн сайн сайхныг бэлгэддэг (Сампилдэндэв 1985, 97). Эцэг эх “насанд хүрсэн хүүгээ гэрлэх”, “хүүгийн утаа харах” гэдэг бол монгол ёсонд уг удмаа үргэлжлүүлэх, гал голомтоо унтраахгүйн учир төрийн хэрэг хэмээн ойлгож, “өрх өсгөж, сум сунгана” хэмээх хэллэгээр зүйрлэн ихэд хүндэтгэлтэйгээр ёсолж ирсэн нь өнөө үед уламжлан, шинэ нөхцөлд агуулга нь баяжиж байна (Цэрэнханд 2005, 181). Манай монголчууд эрт үеэс эхлэн найрын тогтсон ёс горимтой явж ирсэн бөгөөд энэ ёс дэглэм нь аймаг, хошуу, орон нутагт өөр хоорондоо нийтлэг ба ялгарах онцлог шинжүүдийг агуулсан байдаг. Найрын зан үйлийн энэ өвөрмөц ёсонд уул нутгийн хүн ардын гарал угсаа, бүрэлдэхүүн, тэрчлэн өнгөрсөн тухайн үеийн нийгмийн үзэл санааны тусгал ямар нэг хэмжээгээр илэрлээ олсон байдаг тул тэр ард түмний үндэсний онцлогийг тодорхойлогч гол хүчин зүйлийн нэг нь байдаг билээ (Монгол судлалын үндэсний зөвлөл 2023, 27).

Захчины хуримлах ёслолын талаар 2002 онд “Монголын утга соёлын өвийн үндэсний төв” Ховд аймгийн Манхан сумын нутгийн иргэд, ардын авьяастнуудыг оролцуулан “Алтан тулга, мөнгөн тотго” 2 ангит баримтат киног бүтээсэн. Энэхүү баримтат киноны 1-р ангид *хуримын өмнөх, хуримын үеийн* зан үйлийг дүрслэн үзүүлснийг “Алтан тулга, мөнгөн тотго” баримтат кинонд хийсэн шинжилгээ

сэдэвт өгүүлэл болгон хэвлүүлсэн билээ. Иймд энэхүү өгүүлэлд баримтат киноны 2-р ангид дүрслэгдсэн захчины хуримын зан үйлийг судлаачдын бүтээлд тэмдэглэгдсэн уламжлалт хуримын зан үйлтэй нь харьцуулан судалж, баримтат кинонд хэрхэн баримтжуулж, хадгалсныг тодруулахыг зорилоо.

### Судалгааны арга зүй

Захчины хуримын зан үйлийн талаар хэвлэгдсэн судалгааны материалуудад анализ хийж, баримтат киног үзэн идэвхгүй оролцоо бүхий ажиглалт хийж, соёл бэлгэдлийн утгыг тайлах аргыг ашигласан.

### Судалгааны үр дүн

“Алтан тулга, мөнгөн тотго” баримтат киноны 2-р ангид **хуримын үеийн** зан үйлийг үзүүлжээ. Тухайн ёслолд хамаарах зан үйлүүд хэрхэн дүрслэгдсэнийг уламжлалт хуримын зан үйлийг судалсан Г.Мэнэс, Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх нарын судалгаатай харьцуулан шинжиллээ. Энэхүү баримтат кинонд захчин хуримын үеийн зан үйлээс **хуримын мэдээ, бэр мордуулах, бэр буулгах, бэр мөргөх, сэв нийлүүлэх, шинэ гэрийн хурим, эхийн цагаан сүүний харамж** зан үйлүүдийг илэрхийлсэн байна.

**Хуримын мэдээ:** Захчины хуримын ёслолд хоёр талын худ ургийн харилцааг баталгаажуулах ёслолын шинжтэй үйл явц юм. А.Баасанхүү, Б.Батмөнх нарын судалгаанд энэ талаар тэмдэглээгүй. Г.Мэнэс ...хүүгийн талаас нэг хүн хүүхний талд очиж, ламаас асууж тогтоосон хуримын өдөр, цагийг мэдэгдэн, хоёр талын төрлийн ахлаач, төрөл садан, хуримд оролцох хүмүүсийн тоо, хүүхний ачаа бараа, унах ачих хөсгийн тооцоо, бэр мордуулах, очиж буух зэргийг хэлэлцэн хуримын мэдээг хүргэдэг.. (Мэнэс 1996, 357), Ц.Баасандорж, А.Очир нар ...хуримын урд орой хуримын мэдээ хүргэнэ. Охиныг хэдэн цагт авах, хэдэн цаг найрлах, зөөлөн бараа хэд байх, охины аав хэзээ очиж цай уух зэргийг тохирно (Баасандорж, Очир 2019, 110) хэмээн тэмдэглэжээ.



Зураг 1. Хуримын мэдээ хэлэлцэж байгаа нь<sup>1</sup>

Баримтат кино нь хүүгийн талын зууч, нэг хүнтэй хамт идээ цагаатайгаа охины талд очиж, хуримын мэдээг хэлэлцэхээр орж буйгаар үйл явдал эхэлнэ (Зураг 1). Хүүгийн талын зууч:

*Заа азай буурал аав, ачит буурал ээж ах дүү төрөл төрөгсөд хуран цугларсан хуримчин найрчин та бүхэндээ бид*

<sup>1</sup> Мөнхзөг, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.

*Дээгүүр үүлэн холбоо*

*Доогуур өвсөн хэлхээ болохоор*

*Худ ургийн барилдлага тогтоохоор*

*Хоёр хүүхэд маань сэдэж*

*Хамт олон маань элбэж*

*Хуримын ажлаа хийхээр хэлэлцэж товлосон ёсоор*

*Худын магнай тэнийлгэж хуримын мэдээ барьж бид ирсэн билээ*

*Азай буурал аав, ачит буурал ээж ах дүү төрөл төрөгсөд хуримчин найрчин хуримын даа<sup>2</sup> та бүхэнд хуримын мэдээ идээ дэвшүүлнэ үү гээд тамхи бараалхуультаа гэж охины эцэг эх, найрын даатай амар мэнд мэдэн хөөрөглөж, ерөөлийн үгсээр зорьж ирсэн хэрэг явдлаа танилцуулж байна. Кинонд хуримын мэдээ хэлэлцэх явцад судалгаанд дурдагдсан бэр хүргэнийг цагаалуулах, бэр буулгах зүг чиг, гар цайлгалтад оролцох хүмүүсийн тоо, хуримын үргэлжлэх хугацаа, уур барих буюу идээ шүүс бэлтгэх асуудал зэргийг тусгажээ. Жишээ нь, бэр мордуулах цагийг “Хулгана өдрийн туулай цаг заасан”, “Тавтаа<sup>3</sup> наран тусаж байдаг туулай цаг”, бэр буулгах зүг чигийг “Хийморийн зүгтээ мордоод хишигийн зүгээсээ бууна аа гэсэн тэр нь болно. Хонь жилтэй охин уул суудалтай 24 настай тэгэхээр баруундаа хийморийн зүг нь байна аа. Баруун урдаасаа хишигийн зүг байна”, “Баруундаа мордоод хүүгийн зүг тийм байна гээд баруун өмнө буусан” зэрэг киноны харилцан ярианд гарч буй хэллэгүүдээр илэрхийлжээ.*

**Үүдэн дарлага:** Баримтат кинонд хүүгийн талынхныг ирэхэд охины талын найрын даа (Зураг 2):

- *Жаа энэ чинь үхэр мал хотноосоо гараагүй, хүн амьтан ор дэвсгэрээсээ босоогүй, үүрийн харанхуй бүрэнхийгээр яарч сандарч ямар ажлаар яваа улсууд<sup>4</sup> вэ та нар?*

Хүүгийн талын зууч:

- *Жаа газрын холоос усны уртаас дээгүүр үүлэн хэлхээ, доогуур үндсэн холбоотой болохоор худ ургийн барилдаа тогтоохоор танай өргөөг зорьж ирсэн билээ бид.*

Охины талын найрын даа:

- *Жаа тэгэхээр ахлагч амархан морилж ирцгээж байна уу?*

Хүүгийн талын зууч:

- *Сайн морьд маань цуцсангүй ээ, саадтай явдал тохиолдсонгүй ээ, садан ургийн газартаа сайн явж ирлээ. Энх тогтоож төгс бүрдсэн арван ах дөрвөн дүүгээ дагуулж эрхэм сайхан хүргэн чинь асар их өргөөнд чинь бараалхаж луу шүтээнд чинь мөргөж зул хүж өргөх гэж ирэхэд маань байцааж асуугаад оруулдаггүй ээ баганаар үүдээ дардаг нь учир юун билээ.*

Охины талын найрын даа:

- *Ургамал ногоо чулуу ч усыгаа дагаж ургадаг, улс хэдий мэргэн ч урьдын журмыг дагадаг юм. Ингээд байцаажинав.*

<sup>2</sup> Захчин хурим найрын ахлагч, ахлаач (Баасанжав, Амгалан 2021, 113)

<sup>3</sup> Тайван, сайхан (Баасанжав, Амгалан 2021, 324)

<sup>4</sup> Хүмүүс (Баасанжав, Амгалан 2021, 324)

Хүүгийн талын зууч:

- *Ган говийг туулаад ирлээ, газрын холоос ирлээ. Агт морьд атан шараас урьтаад ирэв ээ, аав ээж ах дүү нар минь ээ алтан хаалгаа нээж хайрлана уу. Баруун биеэр суусан бахтай ах нар минь ээ, зүүн биеэр суусан зүйтэй сайхан эгч нар минь ээ, алтан бумбынхаа амыг тайлж хайрлана уу, алтан бумбынхаа амыг тайлж хайрлана уу, алтан бумбынхаа амыг тайлж хайрлана уу та бүхэн*

Охины талын найрын даа:

- *Жаа гээд үүдийг нээв.*



Зураг 2. Үүдэн дарлага<sup>5</sup>

Баримтат кинонд охины талын найрын ахлаач гэрийн гаднаас ацтай модоор үүдээ дарж байгаагаар үзүүлсэн нь судалгааны бүтээлд үүдээ дотроос нь бэхэлдэг гэж тэмдэглэсэнтэй харьцуулахад орон зайн хувьд өөрчлөгдсөн ч үүдэн дарлагын харилцаа шүлэг нь хэвээр хадгалагдаж байгааг харуулна. 1978 онд Ц.Аюушийн Ховд аймагт явуулсан угсаатны зүйн хээрийн судалгааны тайланд Ч.Ламбийгаас тэмдэглэснээр ...бүүр дээр үед хүү тал шөнө дунд ирээд улаан нарнаар л охиныг авч мордож байсан. Бэр авч гарах нь бар цаг өнгөрөөд туулай цаг дээр таарч байв (Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 238) гэжээ. Баримтат киноны хуримын мэдээнд дурдсан “Тавтаа наран тусаж байдаг туулай цаг”-т бэрийг мордуулах, үүдэн дарлагын үеэр “Жаа энэ чинь үхэр мал хотноосоо гараагүй, хүн амьтан ор дэвсгэрээсээ босоогүй, үүрийн харанхуй бүрэнхийгээр яарч сандарч ямар ажлаар яваа улсууд вэ та нар?” гэж хэлдэг үгс нь дээрх цаг хугацааны ойлголттой агуулга, утгын хувьд бүрэн дүйж байна.

Охины гэрт хүүгийн талынхан ороод хуримын мэдээний үед хэлэлцсэн хүргэн цагаалах, уур барих, гар цайлгах ёслолыг дүрсжүүлжээ. Хүүгийн талын зууч:

- *Жаа азай буурал аав, ачит буурал ээж энд хуран цугларсан хуримчин найрчин та бүхэн хамт олон та бүхэнд хүргэн хүүг цагаалуулья аа* гэхэд хүү хадам аав, ээжтэйгээ хадаг барин цагаална.
- *Жаа хуримын идээ, уурын идээ, барааны идээ хамтад нь бараалхуулахыг зөвшөөрнө үү* гэж охины аав, ээж, найрын даагаас зөвшөөрөл эрэн тус бүртэй нь хөөрөглөж зөвшөөрөл авав.

<sup>5</sup> Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.*

Хүүгийн талын бүтэн болгож тулманд хийж авчирсан хонины энэ махыг “уурын хонины цав” буюу эсвэл “уурын идээн” гэж хэлдэг. Ингээд хүүгийн тал идээний дээжээ алтан дэлхий, гал голомтонд нь өргөөд дараа нь хүүхний талын хүмүүсийн “гар цайлгана” гэдэг нэгэн ёс гүйцэтгэдэг (Мэнэс 1996, 359). Уурын 9 хадаг хэмээн охины аав, ээж, авга нагацын гол 9 хүнд хадаг барина. Энэ 9 хадгийг хүргэн болох залуу барих ба энэ үед хүргэнийг улайлгах зорилгоор гал маш сайн түлнэ (Баасанхүү, Батмөнх 2010, 186). Үүний дараа баримтат кинонд хүүгийн талын зууч: *Цогбадрах миний хүү босоод зогсож бай, найрын даа, авга, нагац, төрлийг чинь танилцуулна. Их ах, бага ах, нагац ах гэх мэтээр таньж ав. Бэр нь бэрлэдэг, хүргэн нь очиж золгодог ийм зан заншилтай байдаг юм. Үүнийгээ мэдэж ав миний хүү* гэхэд охины талын найрын даа: *Том авга ах Бямбаа, их нагац Даваажав, хүргэн ах Төмөрбаатар* гэх мэтээр танилцуулахад хүүгийн талаас хамт ирсэн нэг хүн очиж хадаг өгч гар цайлгаж байна. Ингээд худгуйн тал зоог, цаваа оруулж ирээд хуримлагсад эрэмбэ дэсээр тавьж найр эхэлдэг. Энэ дайллагаар хүргэний өмнө шагайт чөмөг голлуулсан зоог тавьж хүргэнийг сорьсон шинжтэй нэгэн ёслол болдог. Хүргэн хүү зоогт гар хүрэн шагайтын нарийн талаас хөндлөн гурав хэрчиж амсаад тавихад, тэр чөмгийг залуугийн дагуул бүтэн мөлжөөд цагаан даавуугаар ороож хүмүүст өгч тойруулдаг (Мэнэс 1996, 359). Баримтат кинонд хүүгийн дагуул шагайт чөмгийг цагаан даавуунд ороож хүүгийн бүсэнд хавчуулав (Зураг 3). Энэхүү ёслолыг баримтат кинонд Г.Мэнэсийн тэмдэглэсний дагуу хүүгийн талын идээ зоог оруулсны дараа үйлдэж байна. Харин Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх нарын судалгаанд дарааллын хувьд өөрөөр тэмдэглэжээ. Охины ачааг хүлээлгэж, ачаа ачуулсны дараа охиныг төрсөн гэрт нь оруулан хүргэн болох залуутай хамт суулгаж цайлна. Ингэхдээ сэвгэрт өвчүү, хүүд шагайт чөмөг тавьж өгнө. Хүү шагайт чөмгийг мөлжиж өвөртлөнө гэжээ.



*Зураг 3. Шагайт чөмгийг мөлжөөд цагаан даавуунд ороож хүүгийн бүсэнд хавчуулж байгаа нь<sup>6</sup>*

Баримтат кинонд охины аав: *за Цогбадрах миний хүү, тэр бууг аваад ир аав нь халияа<sup>7</sup>* гэхэд дагуулын хамт бууг өргөөд аавдаа хүргэж өгөв (Зураг 4). Охины аав нь бууг үзээд цэнхэр хадаг аманд нь уяад *энэ одоо яадаг буу болж байна* гэж асуухад хүүгийн талын зууч:

<sup>6</sup> Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. Алтан тулга, мөнгөн тогто баримтат кино.

<sup>7</sup> Юмыг харах, үзэх (Баасанжав, Амгалан 2021, 383)

*Таван зууд тусдаг тахь яахан  
Зургаан зууд тусдаг зураг яахан*

Одоо мянга таван зууд тусдаг цахиур буу гэдэг буу даа. Манай Эрдэнээн аавын аавын хөрөнгө гэсэн биш үү. Одоо энэ хөвүүнд 4 дэх үе дээрээ явж байгаа эд гэж байна. Харин судлаачдын бүтээлд охины аав бууны тухай асуухад Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх нар хүргэн нь хариулдаг гэсэн бол Г.Мэнэс хүүгийн талын зууч хариулдаг гэжээ. Энэ хариуг сонссон эцэг хүүгийн бууг их сонирхон үзэж сүмбэ эсвэл аманд нь хадаг уяж хүүд хоёр гардан өгөхөд, хүү буугаа авч өөрийн суугаа газраа тавьдаг гэж тус тус тэмдэглэжээ.



*Зураг 4. Хүүгийн буунд хадаг уяж байгаа нь<sup>8</sup>*

Бууг хадам аавдаа өгөн шинжүүлсний дараа хүү малгайгаа тайлаад хормойгоо дэвсэн тулганы доор суув. Хадам аавын гал голомтод мөргөх үед хүүгийн найрын даа “энэ айлын гал бурханд би хөвүүн чинь боллоо гээд дотроо бодоод залбирч мөргө өө” гэж чиглүүлж байна (Зураг 5).



*Зураг 5. Хүү тулганд мөргөж байгаа нь<sup>9</sup>*

Үүний дараа хүү хадам аавтайгаа хөөрөглөөд мөнгөн аягатай сүү амсахад хадам аав нь хүүд бүс бүслүүлж, хүрэм өмсгөв (Зураг 6). Энэ нь одооноос “манай хүн боллоо” гэсэн утгыг илэрхийлж байна (Туулцэцэг, Маралмаа 2023, 111). Хүргэнд бүс бүслүүлж өөрийн хүн болгох нь баян, ядуу ялгаагүй адил байгаа нь монголчуудын бүсийг эрхэмлэдэг бэлгэдэлт сэтгэлгээний онцлог юм. Бүс бүслүүлснээс хойш хүргэн хүүхний аав, ээжийг хадам аав, хадам ээж гэж нэрлэнэ. Энэ үеэс эхлэн хадам аав, ээж нь хүргэн гэж дуудах ёстой. Хүрэм өмсгөөд бүс бүслүүлж байгаа нь онгон шүтээнээ хилэгнүүлэхгүй харь овгийн хүнийг овогтоо хүргэн оруулж байгаа далд утгатай (Эрдэнэцэцэг 2015, 60). Хадам ээж нь дээл,

<sup>8</sup> Мөнхзөгс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.*

<sup>9</sup> Мөнхзөгс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.*

хөгшин ээж нь гүү өгч байна. Хүргэндээ бэлэг өгөхдөө хадам ээж “Сайхан айл болж яваарай миний хүү” хэмээн ерөөсөн нь шинээр гэр бүл болж буй хосын амьдралыг эв найртай, тогтвортой авч явахыг, хөгшин ээж нь “Хүрэн гунжин<sup>10</sup> гүү авч малыг нь өсгөж яваарай” хэмээн захиж эм мал өгч байгаа нь уламжлалт мал аж ахуйн сэтгэлгээтэй холбоотой эд хөрөнгө арвижих, өсөхийг бэлгэджээ. Охины талын авга, нагац нар нь “Сайхан айл болж яваарай миний хүү”, “Амьдралдаа аз жаргалтай, сайн сайхан айл болж амьдарч яваарай миний хүү”, “Айлын дээд айл, хүний дээд хүн болж яваарай” гэж ерөөлөө хэлж байна. “Айлын дээд айл” гэдэг нь тухайн гэр бүлийг нэр хүндтэй, үлгэр жишээ байхыг, “хүний дээд хүн” гэх нь хувь хүний ёс суртахуун, хариуцлага, хүнлэг чанарыг эрхэмлэхийг бэлгэдсэн, бөгөөд ерөөлд давтагдаж буй “сайхан айл” гэх ойлголт нь ахуй амьдралын хангалуун байдал төдийгүй харилцан хүндлэл, ойлголцлыг хамтад нь илэрхийлсэн болов уу. Баримтат кинонд охины талын найрын даа хүүг бэлэг хүлээн авах үед “духандаа хүргэж ав, аав, ээжийн хишигийг хүндэтгэлтэй авна аа хө” хэмээн сануулж буй нь бэлэг, ерөөлийг зүгээр нэг эд зүйл бус, эцэг эх, ахмадын адис, хишиг хэмээн ухамсарлан хүндэтгэх ёс суртахууны үнэт зүйлийг илэрхийлж байна.



Зураг 6. Хадам аав нь хүүд бүс бүслүүлж, хүрэм өмсгөж байна<sup>11</sup>

Баримтат кинонд хүүгийн талын найрын даа ерөөлөө хэлээд охины аавд бэрийн ачаа барааны тамхийг өгч хөөрөглөснөөр бэрийн ачаа ачих, бэр мордуулах зан үйл эхэлж байна. Судлаачдын тэмдэглэснээр ачаа ачих ёслолын үед охин өөр айлд, эсвэл бага гэрт байрлаж, ачаа ачуулсны дараа охиныг төрсөн гэрт нь оруулж ирдэг заншилтай байжээ. Гэвч баримтат кинонд уг уламжлалаас зөрүүтэйгээр охин өөрийн гэрт цагаан хөшигний цаана сууж байна (Зураг 7).



Зураг 7. Охиныг мордуулахаар хөшигний цаанаас гаргаж байгаа нь<sup>12</sup>

<sup>10</sup> Гурван настай эм мал (Баасанжав, Амгалан 2021, 102)

<sup>11</sup> Мөнхзөгс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.

<sup>12</sup> Мөнхзөгс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.

Энэхүү зөрүүтэй дүрслэл нь нэг талаас баримтат кино хийх үед орон зайн боломж, гэр сууцны хүрэлцээ зэргээс шалтгаалан зохион байгуулалтыг өөрчилсөн байж болзошгүйг, нөгөө талаас 2002 онд охиныг цагаан хөшигний ард суулгах зан үйл түгээмэл болж, ёс заншлын тодорхой өөрчлөлт байж магадгүйг харуулж байна. Киноны дүрслэлд охиныг хоёр талаас нь бэргэд сугадан моринд мордуулж, урдуур нь хоёр эрэгтэй цагаан хөшиг татан явж байгаа (Зураг 8) нь нийт судлаачдын тэмдэглэлүүдтэй таарч байна.



Зураг 8. Бэрийг мордуулж байгаа нь<sup>13</sup>

**Бэр буулгах:** Баримтат кинонд бэрийг ирэхэд гэрийн гадаа цагаан эсгий дэвсэж, тариагаар тамга хийжээ. Бэргэд сугадан орох ба тамган дээр гишгэн гэрт орж байна (Зураг 9). Эсгий дээр тухайн айлын малын тамгыг будаа тариагаар хийж, дээр нь бэрээ буулгаж байгаа нь тэдний галын хүн болсныг илтгэхийн зэрэгцээ үр хүүхэд олонтой, үрээ малаар арвин явахыг бэлгэдсэн зан үйл юм (Туулцэцэг, Маралмаа 2023, 113). Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх нарын судалгаанд “шинэ гэрийн үүдэнд ирж тариагаар тамга зурсан цагаан эсгийн дээр бууж”, Г.Мэнэсийн судалгаанд “тариагаар хас тэмдэг тавьсан ширдэг юм уу, эсвэл цагаан эсгийн дээр бэрээ буулгадаг” гэж тэмдэглэжээ. Шинэ гэрийн үүдэнд цагаан эсгий дэвсэж бэр буулгаж байгаа нь хиргүй цагаан сэтгэлээр угтаж байгаа бэлгэдлийг илэрхийлнэ. Хас гэдэг нь “хоёр хос юм” гэсэн монгол үг байна. Нэг эр тэмдэгтэй хоёр эм тэмдэг нийлүүлж хос болгоод, түүнийг дахин хосолсноор сая хос болно (Нямбуу 2023, 492).



Зураг 9. Бэр гэрт орж байгаа нь<sup>14</sup>

Бэрийг гэрт оруулах үед хоёр талын эх хамт орж ирэн, улмаар бэрийг хөшигний ард суулгаж буй дүрслэл баримтат кинонд гардаг. Харин Г.Мэнэс,

<sup>13</sup> Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.*

<sup>14</sup> Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.*

Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх нарын судалгаанд охины эцэг, эх хуримд биечлэн оролцдоггүй, бэрийг мордуулах ёслолд зөвхөн авга, нагац, дагуул, бэргэн зэрэг цөөн хүн хүргэж өгдөг “*Дөрвөн аав, ээж зөв гэдэгт, дөчин хүмүн найр хийдэг*” гэсэн үг байдаг гэж тэмдэглэжээ. Иймээс дээрх судлаачдын “эцэг эх хуримд оролцдоггүй, бэрийг мордуулах ёслолд хамт явдаггүй” гэсэн нь баримтат киноны дүрслэлтэй зөрчилдөж байна. Гэсэн хэдий ч үүнийг бүхэлд нь уламжлалт ёсны алдаа хэмээн үзэх боломжгүй. Учир нь 1978 онд Ц.Аюушийн Увс, Ховд аймагт хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны тайланд *охиноо хүргэхээр эх нь* (Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 239), *охиноо хүргэж өгөхөөр охины эх* (Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 251) гэж тэмдэглэжээ. Энэ нь бэрийг зөвхөн эх нь хүргэж өгдөг заншил нийт монголчуудын дунд оршиж байсныг харуулж байна. Өөрөөр хэлбэл, бэрийн эх хуримд оролцож болох ч, эцэг нь тухайн өдөр оролцдоггүй, харин гурван хоногийн дараа “эргэлт” хэмээх ёслолоор ирж, хөшиг тайлах найрт оролцдог уламжлал түгээмэл байжээ. Үүнтэй холбоотойгоор “*Эх хүргэлтэнд, эцэг эргэлтэнд*” гэсэн зүйр үг гарчээ (Сампилдэндэв 1985, 113). Нийгэм соёлын өөрчлөлт, нөхцөл байдлаас шалтгаалан хувьсан, хүүгийн эх бэрээ очиж авах, охины эх охиноо хадмын газар хүргэж өгөх заншил түгээмэл болсон байна. Иймд баримтат кинонд дүрслэгдсэн хоёр эх хамт оролцож буй үзэгдэл нь уламжлалт ёсыг шууд зөрчсөн бус, түүхэн хувьсал, нутгийн ялгаа, орчин цагийн ойлголттой огтолсон нэгэн хувилбар гэж дүгнэж болох юм.

**Сэв нийлүүлэх:** Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх, Г.Мэнэс нарын судалгаанд бэргэд хоёр залуугийн үсийг “сэв нийлүүлэнэ” хэмээн үсийг нь нэгтгэн самнасны дараа боодгийг сольж, улмаар бэрийн үсийг хоёр тал руу нь самнан үсний гэр шургуулж, авгай цэгдэг, тэрлэг өмсгөн авгай болгодог гэж тэмдэглэжээ. Энэ нь эхнэр хүний нийгмийн статуст шилжиж буйг бэлгэдсэн зан үйлийн чухал үе шат юм. Баримтат кинонд бэргэд зөвхөн бэрийн үсийг самнаж байна. Хоёр залуугийн үсийг “сэв нийлүүлэнэ” самнах үйл явц, бэрийн хувцсыг солих ёслол огт дүрслэгдээгүй. Бэр өөрийн гэрээс мордох болон хүүгийн талд очихдоо нэгэн ижил хувцастай байна. Энэ зөрүүг угсаатны зүйн хээрийн судалгааны бусад эх сурвалжтай харьцуулахад илүү тодорхой харагдана. Тухайлбал, Ц.Аюушийн 1978 онд Увс, Ховд аймагт хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны тайланд, *охин айлд одохын өмнө гурван боодог зүүж, гурван хоногийн дараа авгай хувцас өмсөн айлын бэр болон очдог бөгөөд цагаан захтай улаан өнгийн хувцсыг эх эцгийн гэрт үлдээдэг* (Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 156), *охин цэгдэг, тэрлэг өмсөхгүй, зөвхөн халхаартайгаар айлын бэр болон очдог* (Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 238) тухай дурдсан нь зан үйлийн хэлбэр нутаг нутгийн онцлогоос хамааран ялгаатай байсныг илтгэнэ.

**Бэр ерөөх ёс:** Уламжлалт хуримын зан үйлд бэр шинэ гэрт сэв нийлүүлэн, эхнэр хувцас өмсөөд, гэрээс гарч шар нар, шагайт чөмгөнд мөргөсний дараа хадам аавын гэрт ороход гэрийн зүүн багсанд<sup>15</sup> хөшиг татсан байдаг бол баримтат кинонд

<sup>15</sup> Хана хатавч (Цолоо1988, 73)

шинэ гэрт сэв нийлүүлсний дараа үйлдэж байгаа нь *дарааллын хувьд*, аавын гэрт хөшиг татсан байдаг бол баримтат кинонд хүүгийн шинэ гэрт цагаан даавуугаар хөшиг татаж бэрийг суулгасан нь *орон зайн хувьд* өөр байна. Хөшиг сөхөж бэр ил гарч хадам аав, ээж, хадмын талын хүмүүст мөргөдөг бол энэхүү баримтат кинонд хадам аав, ээжид мөргөсөнгүй. Хэдийгээр хөшиг сөхөж бэр ил гарах зан үйлийн дараалал өөр байгаа боловч уламжлалт хуримын бэрийн өмнүүр татсан хөшгийг сөхөхөд хэлэх үг ижил байна. Хадам аав асуух бүрт найрлаж суугаа хүмүүс *хүнд ээ хүнд* хэмээн хариулж байгаа нь залуу хосыг тогтвор суурьтай амьдрахыг бэлгэдсэн ерөөл юм. Мөн уламжлалт хуримын зан үйлд хөшгийг сөхөхдөө бууны сүмбэнд хадаг уядаг ёсыг энэхүү баримтат кинонд харуулжээ. Бууны сүмбэ хэрэглэх нь гэр бүлд эр хүний эрх, байр суурийг илэрхийлж байна. Баримтат кинонд хадам аав нь хөшиг сөхөж бэр ил гарсны дараа бэрийн талын найрын ахлаач: *За миний охин аавтайгаа цагаалчих*<sup>16</sup> *аа* гээд хадаг өгнө. Бэр эхлээд хадам аавтайгаа дараа нь хадам ээждээ хадаг барин золгож байгааг дүрслэн үзүүлжээ. Харин уламжлалт хуримын зан үйлд найрын ахлаач биш бэргэд туслах үүрэгтэй байжээ. Бэргэн гэдэг нь ураг холбох хуримд хоёр талаас тусгайлан бэлтгэсэн зууч нарыг хэлдэг байв. Бэргэн хуримд голлох үүрэгтэй оролцоно. Хоёр талын бэргэд зохион байгуулах авьяас чадвартай, ёс заншлаа сайн мэддэг, хэл ярианы хөгжил сайтай, элэг бүтэн хүн байвал сайн гэнэ. Бэргэд бол зөвхөн хуримд үүрэг гүйцэтгээд өнгөрөх биш, цаашдын амьдралын зөвлөгч болдгоороо онцлог юм. Мөн бэр хадам аав, ээжтэйгээ золгосны дараа бэр тал хүргэн талын хүмүүсийн гар цайлгаж, бэлэг өгдөг бол энэхүү баримтат кинонд энэ талаар гарсангүй.

**Бэрийн цай уух:** Баримтат кинонд хүргэний шинэ гэрийн тулганд тогоо дүүрэн сүүтэй цай чанаж байна. Хүргэний ээж шанаганы бариулд цагаан хадаг уяад тогоотой цайг нар зөв эргүүлэн гурав самарна. Үүний дараа бэр тогоотой цайг нар зөв эргүүлэн гурав самарна. Хоёр бэргэн цайг аягалахад бэр эхлээд нөхөртөө барина (Зураг 10). Уламжлалт хуримын зан үйлд тогоо дүүрэн чанасан цайг хадагтай шанагаар огт салгалгүй хоймор зүг нар зөв эргүүлэн гурав самраад, мөн тогоогоо өргөж хүйсэнд нь тос түрхэн мялаагаад тогоогоо дахин засахгүйгээр тэгш тавих нэгэн сорилтыг давдаг байжээ (Мэнэс 1996, 363). Баримтат кинонд бэр цайг шанагаар самрах, нөхөртөө цайны дээжээ барих зан үйл гарч байна. Бэрийн анхны цай гэдэг бол тухайн хүний мэдрэмж, сэтгэл зэргээс хамаарч цайны амт, өнгө, үнэр өөр өөр болох тул чанасан цай нь бэрийн дотоод сэтгэлийг тод харуулдаг хэмээн үзнэ. Иймд шинэ бэрийг хэр төвшин болохыг тогоо тавьсан байдлаас, хэр амны хишигтэйг цайны өнгө, амт, үнэр зэргээс дүгнэж хадам эцэг, эх бэрдээ хандах хандлагад ямар нэг байдлаар нөлөөлдөг байжээ. Учир нь идээ, цагаа өнгөтэй, цай амттай байвал айл гэр өнгөтэй, дулаан байна гэж үздэгтэй холбоотой. Бэрийн цай уух нь хэр зэргийн амны хишигтэй бэр ирснийг тодорхойлж, бэрийнхээ бурууг зааж, зөвийг залах зорилготой (Эрдэнэцэцэг 2015, 71).

<sup>16</sup> Золгох (Баасанжав, Амгалан 2021, 417)



Зураг 10. Бэрийн цай уух ёс<sup>17</sup>

**Шар нар, шагайт чөмгөнд мөргөх:** Ойрад монголын ихэнх угсаатны зан заншилд бэрийг буулгасны дараа шагайт чөмгөний бүдүүн талаас эр нөхрийг нь атгуулж, нарийн талаас нь бэрээ атгуулж шар нар, шагайт чөмгөнд мөргүүлдэг ёс байжээ. Гэр бүл болсон айл хуримын үеийн шагайт чөмгийг толгой талынхаа дэрэнд хийж насан үүрд хадгалдаг байсан байна (Нямбуу 2023, 391). Сэв нийлүүлсний дараа гэрийн урд дэвссэн хонины арьс эсвэл ширдэг дээр суулгадаг (Мэнэс 1996, 361). Уламжлалт хуримын ёсонд сэв нийлүүлсний дараа мөргөх ёслолыг үйлддэг бол баримтат кинонд бэрийн цай уух ёсны дараа үйлдэж байгаа нь дарааллын хувьд өөр байна. Хормойгоо урагш нь тосоод суухдаа судлаачдын тэмдэглэснээр зүүн гар талд буюу орон зайн хувьд зөв суужээ (Зураг 11).



Зураг 11. Шар нар, шагайт чөмгөнд мөргөж байгаа нь<sup>18</sup>

**Тулганд мөргүүлэх ёс:** Уламжлалт хуримын зан үйлд хадам аавын гэрт бэрийн өмнүүр татсан хөшгийг сөхөж бэрийг ил гаргах, бэр хадам аав, ээж, төрөл төрөгсдөд нь мөргөх, бэрийн анхны цай уух гэсэн дараалалтайгаар эдгээр ёс, ёслолуудыг үйлдэнэ. Баримтат кинонд хүүгийн шинэ гэрт бэр ил гаргах, бэрийн анхны цай уух ёслолууд болж байгаагаараа ялгаатай. Бэргэд охиныг хөтөлж тулганы урд талд ямааны арьсан дээр сөхрүүлэн суулгаад:

*Хайлаас модон хөгжсөөнтэй*

*Хаш чулуун дэвсгэртэй*

*Ган төмөр хүрээтэй*

*Хан аавын цахин бадраасан*

*Хатан ээжийн үлээн хөгжөөсөн*

*Галын хаан Мьяранз бурхандаа*

<sup>17</sup> Мөнхзөгс, Г. (зох.), Жамсран, Г. (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.*

<sup>18</sup> Мөнхзөгс, Г. (зох.), Жамсран, Г. (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.*

*Өөх, тос, өнгийн хувцсыг өргөн барьж сөгдөн мөргөө өө* гэнэ. Охин мөргөх бүртээ тулганд арц өргөнө. Тулга бол өрх, гэрийн гал голомт бөгөөд түүний гурван хөл нь гэрийн эзэн, эзэгтэй, бэр гурвыг төлөөлдөг гэж үздэг заншилтай. Ингээд хадам эцэг нь баруун тал, хадам эх нь зүүн тал, бэр урд талд буй байдлаар тулга тулдаг ёс дэлгэрсэн байна. Иймд бэр хадмын гал голомтод мөргөхдөө тулганы урд хөлд мөргөдөг ёстой ажээ. Бэр мөргөх үед хэлдэг уран холбоо үг нь галын магтаал, тахилгын үгийн чанартай бөгөөд эртний хүмүүсийн галын шүтлэгтэй холбогдон үүсжээ (Сампилдэндэв 1985, 106). Галд мөргөх ёслол нь галыг эрт дээр үеэс ариун чанартай гэж хүндэтгэж, түүнд гэрийн гал голомтын эзэн онгон сахиус оршдог гэж итгэн шүтэн биширч тахиж ирсэнтэй холбоотой.

**Айргийн хөхүүрт мөргөх ёс:** Баримтат кинонд охин галд мөргөсний дараа хөхүүртэй айргийн дэргэд ирэхэд охины талын найрын ахлаач ямааны арьсыг газар дэвсэнэ.

*Зааны ясан көкүүртэй*<sup>19</sup>

*Зандан модон бүлүүртэй*

*Архины эх азай буурал*

*Көрөнгөний*<sup>20</sup> *эх кокшон*<sup>21</sup> *буурал*

*Кокшон ээжийн бүлж исгэсэн*

*Азай буурал айрандаа мөргөө өө* гээд гурав мөргөөд босно. Уламжлалт хуримын зан үйлд бэргэн айргийн бүлүүрт цагаан бөс уяад бэрд өгөхөд гурван удаа айраг бүлээд сууна. Харин энэхүү баримтат кинонд айргийн хөхүүрт мөргөж байна. Айргийн бүлүүрт цагаан бөс уях нь нэг талаар ариун цагаан сэтгэлийн бэлгэдэл болдог нөгөө талаар бүсгүй хүнийг айраг цагааны эзэн гэж үздэгтэй холбоотой. Айрагт мөргөх үед хэлдэг ерөөл нь мал аж ахуйн хөдөлмөр түүний үр шим болсон цагаан идээг эрхэмлэн хүндэлж байсан үзэл санааны илэрхийлэл юм.

**Хүүгийн аавд мөргөх ёс:** Хөхүүртэй айрагт мөргөсний дараа хадам аавдаа гурван удаа мөргөнө. Хүүгийн талын найрын даа: *Өрхөөр орж ирдэг нар нь үүдээр орж ирж одоо Эрдэнээ, Наранцэцэг хоёр охин хүү наймтай байсан бол охин хүү естэй болж есөн эрдэнэ бүрдэж энэ бэр чамд мөргөлөө шүү дээ хө.*

Хадам аав нь:

*Над мөргөсөн бол нас чинь урт болог*

*Төрд мөргөсөн бол төмөрнөөс бат болог*

*Хийморь нь хийсээж хишиг буян нь дэлгэрч*

*Өнөр баян айл болж*

*Мөргөсөн үр минь мөнх жаргалтай, урт насалж удаан жаргах болтугай.*

*Манайх охин, хүү наймтай билээ. Ес дэх эрдэнэ нь миний охин боллоо. Аавынх нь нэр Эрдэнээ* гээд охиндоо хадаг барина. Бэр мөргүүлэх ёсны далд утга нь ёс суртахууны эрхэм дээд чанар болсон ачлал элбэрлийн журмыг сахиулж, үеэс үед тасралтгүй хөгжиж ирсэн гал голомтыг нь дээдлэн, өвөг дээдсийнх нь шүтээнийг хүндэтгэн, буурлаас нь буян гуйж, аав ээжээс нь хишиг ерөөл авч тогтоогоод,

<sup>19</sup> Хөхүүртэй (Баасанжав, Амгалан 2021, 209)

<sup>20</sup> Хөрөнгөний (Баасанжав, Амгалан 2021, 214)

<sup>21</sup> Хөгшин (Баасанжав, Амгалан 2021, 207)

тэр айлын гал голомтыг залгуулах хөвгүүн үр төрүүлж өгье, хишиг буяныг нь дэлгэрүүлэх охин үр төрүүлж өгье, төр түмэндээ өрх өсгөж, сум сунгая гэсэн нандин сайхан сэтгэлийн ариун бат журам юм. Уламжлалт хуримын зан үйлд бэр хадам аав, ээж, хадмын талын төрөл төрөгсдөд мөргөдөг бол энэхүү баримтат кинонд зөвхөн хадам аавдаа л мөргөх зан үйл гарч байна. Урьдаас тогтсон уламжлалыг дагаж тодорхой хэлэлцээрт овгоос нагац талаа түшин гэр бүл болоход (фратрия) ургийн холбоот овгууд нь нэгэн ижил шүтээн, гал голомтод хамаарч, овгийн тамга нь ижил байх нь олонтой байсан учир харь овгийн хүнийг овогтоо элсүүлж мөргөлийн ёс гүйцэтгэх шаардлагагүй байсан бол харь овгоос гэрлэх болсон үед энэ бүхэн зайлшгүй хэрэгтэй болжээ. Нөгөөтгээгүүр тэр үеийн хүмүүсийн ойлголт ёсоор шүтлэг, гал голомт, ураг төрлийн системийн хувьд өөр харь овгийн хүнтэй гэрлэнэ гэдэг өвөг дээдсийн уламжлалыг зөрчин онгон шүтээнээ доромжилсон маш их нүгэлтэй үйлс болох байв. Иймд хүчинд автсан буюу хулгайлуулж буй маягаар хүүхнээ өгөх, худын тал ч гэсэн бэрийг ирэхэд гэрт оруулалгүй баганаар үүд дарж саатуулах, бэр гуйх болон гэр бүл болох тухайд ёгт далд үгээр ярилцах зэрэг хуримлах ёслолын зарим зүйлс үүссэн. Энэ нь харь овгийн хүнтэй сайн дураар гэрлэлээ гэж онгон шүтээнээ хилэгнэхээс болгоомжлон түүнийг хуурч, төөрөлдүүлж буйн зориулалттай. Ийнхүү хуримлах ёслолын үндсэн хэсгүүд харь овгоос гэрлэх ёс үүсэн бэхжих явцад үүсэн бүрэлдэж улмаар дараагийн түүхэн үе шат бүхий нөхцөл байдалд зохицон боловсрон хөгжсөн юм (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн 1997, 19). Уламжлалт хуримын ёсонд бэр мөргөх үед хүү аавындаа орж ирдэггүй гэртээ үлддэг ёстой байжээ. Баримтат кинонд уламжлалт хуримын дагуу хүү аавынхаа гэрт орж ирсэнгүй. Хүүгийн талын найрын даа: *Жаа ингэхээр миний хөвүүн энэ цаг мөчөөс эхлээд өнөөдрийн өдрөөс аав ээжийн хажууд чөлөөтэй орж ирж байхаар боллоо. Эрхтэй дархтай орж ирдэг нэг гэр бүл болж энэ гал бурхандаа мөргөж аав ээждээ идээ будааныхаа дээжийг дэвшүүллээ. За ингээд одоо миний хөвүүн магадар өрүүн<sup>22</sup> эхлээд орж ирж галыг нь түлнэ өрхийг нь тат магадар өрүүнээс эхлээд 3 өрүүн<sup>23</sup> чи өрхийг нь татаж галыг нь түлж цай чанана биш үү, одоо ийгээд цээр тайлагдаад бэр гал бурханд мөргөв. Одоо чөлөөтэй орч гарч байгэж хэлнэ.* Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх нар хуримын маргааш өглөө залуу, сэвгэр хоёр эртлэн босож, залуу нь эцгийнхээ галыг түлж, бэр нь цайгаа авч орон, энэ үйлдэл гурван өдөр дараалан давтагддаг хэмээн тэмдэглэсэн. Г.Мэнэсийн судалгаанд ч мөн адил бэр өглөө бүр эрт босож хадмын гэрийн өрхийг татан, цай чанаж өгөх нь тогтсон ёс болохыг дурджээ. Ц.Аюушийн 1978 онд Увс, Ховд аймагт хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны тайланд илүү тодорхой дурдсан бөгөөд *хуримын маргааш өглөө бэр хадам эцгийн өрхийг татаж, гал түлэн, цай үйчихээд гарна. Энэ нь гурван өдөр дараалан үргэлжилдгийг* (Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 292), *хадам эцэг, эх нь бэрийн чанасан цайг хөшиг тайлах хүртэл гурван хоног уудаг* (Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 239) хэмээн өгүүлсэн байна.

<sup>22</sup> Маргааш өглөө (Цолоо 1988, 610)

<sup>23</sup> Өглөө (Цолоо 1988, 718)

**Эхийн цагаан сүүний харамж:** Баримтат кинонд хуримын төгсгөл хэсэгт “эхийн цагаан сүүний харамжийн үг” хэлж охины ээжид бэлэг өгнө (Зураг 12).



Зураг 12. Эхийн цагаан сүүний харамж<sup>24</sup>

Энэ үг нь хүүхэд төрүүлж өсгөсөн эхийн ачлал, хайр халамж, зүтгэлийг уран цэцэн үгээр магтан алдаршуулах аман уламжлал бөгөөд бэлэгт багтсан зүйлсийг тоочин дурдан өгдөг. Эхийн цагаан сүүний харамжийг уламжлалт хэлбэрт ойролцоо харуулсан нь эерэг талтай ч, гүйцэтгэх цаг хугацааны хувьд нийцэхгүй байгаа ажиглагдлаа. Захчины уламжлалт хуримын дарааллын дагуу “эхийн цагаан сүүний харамж” нь хуримын ёслолын үеэр бус, харин **хөшиг тайлах ёслолын үед** гүйцэтгэдэг. Гэтэл баримтат кинонд хуримын үеийн дүрс гарч байхад дуун тайлбар нь хөшиг тайлах ёсны тухай өгүүлж, түүнтэй зэрэгцүүлэн энэхүү ёслолыг үзүүлжээ. Баримтат кинонд дүрслэл, дуун тайлбар хоёрын уялдаа алдагдсанаар үзэгчдэд буруу ойлголт төрүүлэх эрсдэлтэй. Иймд баримтат киног бүтээх явцдаа дуун тайлбар, дүрслэлийн уялдаа, зан үйлийн дэс дарааллыг нарийвчлан баримтлах нь СББӨ-ийн үнэн зөвөөр хадгалах, уламжлуулах, цаашлаад судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглахад ач холбогдолтой. Баримтат кинонд охины ээжид эхийн цагаан сүүний харамжийн үг хэлж, бэлэг өгсний дараа охины талын найрын ахлаач:

- *За ийгээд маануусын унаж ирсэн морины ул нь чилж байгаа хэвтээ байна, хөлөглөж ирсэн морьдын минь хөлс нь хатаж байгаа хэвтээ байнаа. Ийгээд орсон бороо нь арилж, ирсэн гийчид буцдаг энэ жамыг дагаж бид бүхэн ийгээд гэгээтэйхэн мордож, гэр малдаа тэмцье. Азай буурал аав, ачит буурал ээж, авга, нагац, төрөл төрөгсөд, ахалж суугаа найрын даа та бүхэндээ баярлалаа. Хоёр хүүхдийн маань найр түвшин сайхан, ганц үгний зөрөөгүй, гангар хөөрөгний харшаангүй сайхан болж байна. Жаа ийгээд бид бүхэн аян замдаа мордох цаг боллоо та бүхэн тавтай найрлаарай* гээд хөөрөглөнө.

Хурим найрын ерөөлийн сургаалт уянгын шинжтэй өвөрмөц нэгэн хэлбэр нь найр тараах ерөөл юм. Энэ нь хөөлгийн үг, молорын үг, найр тараах ерөөл гэх зэргээр нутаг нутагт өөр нэртэй боловч үндсэн агуулгын хувьд ойролцоо, найр тарах цаг болсныг зочин гийчдэд дохиолон мэдэгдэх үүрэгтэй (Сампилдэндэв 1981, 91). Уламжлалт ёсоор бэр буулгах хуримын төгсгөлд худын талаас найр тарах ерөөл буюу хөөлгийн үг хэлэхэд гэрээс багана барин худгуйнхныг хөөж буй дүр үзүүлдэг гэж тэмдэглэсэн бол баримтат кинонд худгуйн талаас хэлж байна. Ингээд зочид буцах болоход бэрийн ээж, охиныг галын урд суулгаад урд хормойг

<sup>24</sup> Мөнхзөг, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино.*

нь татан дээд захад нь уур, доод захад нь цохиур тариа, будаа, мөнгө зэргийг тавьж, ар хормойг нь хар цагаан 3 чулуу тавьж дараад:

*Хүрсэн газраа хүндтэй*

*Суусан газраа суурьтай бай* гэж сургаалыг хайрлан үлдээдэг заншилтай (Мэнэс 1996, 364).

### Хэлэлцүүлэг

Баримтат кино нь соёлын ой санамж болж, хүнээс хүнд, үндэстнээс үндэстэнд, нэг хугацаанаас нөгөө хугацаанд соёлын баримтат мэдээллийг дамжуулж байдаг харилцааны хэрэгсэл, баримт бичиг юм (Отгонбаяр 2024, 68). Иймд захчин хуримын зан үйлийн ёс ёслол, гүйцэтгэх хугацаа, орон зай, дарааллыг бодит орчин нөхцөлд баримтжуулах нь ирээдүй хойч үедээ өнгөрсөн үеийн өв уламжлалыг дамжуулж, уламжлуулах ач холбогдолтой. Соёлын мэдээллийг баримтат киноны төрлөөр баримтжуулан соёлын ой санамж бүтээх нь цаг хугацаа өнгөрөх тусам үнэ цэн нь өсөн нэмэгдэж буй чанарыг бүрдүүлдэг (Отгонбаяр 2024, 68). СББӨ нь гарт баригдаж нүдэнд харагдахуйц биет зүйл биш тул түүнийг үйлдэх үеийн үйл хөдлөл болон түүгээр дамжин илэрч буй илэрхийллийг баримтат кинонд буулган үлдээхийг хичээх хэрэгтэй. Хуримын зан үйл нь олон зан заншил, ёслолтой байдаг тул тухайн явцыг эхнээс нь дуустал баримтжуулах нь зүйтэй юм.

Захчины уламжлалт хуримын зан үйлийг “Алтан тулга, мөнгөн тотго” баримтат кинонд хэрхэн дүрсэлснийг хүснэгтлэн үзүүлэв.

*Хүснэгт 1. Захчины уламжлалт хуримын зан үйл*

Захчин уламжлалт хуримын зан үйл	“Алтан тулга, мөнгөн тотго” баримтат кино
<b>Хуримын үеийн зан үйл</b>	
Хуримын мэдээ Бэр мордуулах <ul style="list-style-type: none"> <li>• Хүргэн цагаалуулах</li> <li>• Уур барих</li> <li>• Хүргэнд бүс бүслүүлэх</li> <li>• Гар цайлгах</li> <li>• Бэрийн ачаа ачих</li> </ul> Бэр буулгах <ul style="list-style-type: none"> <li>• Сэв нийлүүлэх ёс</li> <li>• Эхнэр хувцас өмсгөх</li> <li>• Шар нар, шагай чөмөг барьж мөргөх ёс</li> <li>• Малгай уралдуулах атаа маргаан</li> </ul> Бэр мөргөх <ul style="list-style-type: none"> <li>• Бэр ерөөх ёс (хүүгийн аавын гэрт)</li> <li>• Галд мөргүүлэх ёс</li> <li>• Айргийн хөхүүрт мөргөх ёс</li> <li>• Аав, ээж, хүүгийн талынханд мөргөх ёс</li> <li>• Бэрийн цай уух ёс</li> <li>• Арьс татах атаа</li> </ul>	Хуримын мэдээ Бэр мордуулах <ul style="list-style-type: none"> <li>• Хүргэн цагаалуулах</li> <li>• Уур барих</li> <li>• Хүргэнд бүс бүслүүлэх</li> <li>• Гар цайлгах</li> <li>• Бэрийн ачаа ачих</li> </ul> Бэр буулгах <ul style="list-style-type: none"> <li>• Сэв нийлүүлэх ёс</li> </ul> Бэр мөргөх <ul style="list-style-type: none"> <li>• Бэр ерөөх ёс (хүүгийн шинэ гэрт)</li> <li>• Бэрийн цай уух ёс</li> <li>• Шар нар, шагай чөмгөнд мөргөх ёс</li> <li>• Галд мөргүүлэх ёс</li> <li>• Айргийн хөхүүрт мөргөх ёс</li> <li>• Хүүгийн аавд мөргөх ёс</li> <li>• Хуримын атаа маргаан (арьс татах, малгай уралдуулах)</li> <li>• Эхийн цагаан сүүний харамж</li> </ul>
<b>Хуримын дараах зан үйл</b>	
Хөшиг тайлах <ul style="list-style-type: none"> <li>• Эхийн цагаан сүүний харамж</li> </ul>	
Бэр төрхөмчлөх	

Хүснэгтэд үзүүлсэн хуримын үеийн зан үйлийн талаар өгүүллийн үр дүн хэсэгт нэлээдгүй тайлбарласан учир хэлэлцүүлэг хэсэгт дахин нурших нь илүүц болов уу. Харин баримтат кинонд хуримын дараах үеийн хөшиг тайлах, бэр төрхөмчлөх зан үйлийг дүржүүлээгүй байна.

Арьс татах, малгай уралдуулах атаа маргаан баримтат кинонд дүрслэгджээ. Хуримын үеийн атаа маргаанууд нь найр хуримыг чимж, түүнд оролцогчдыг хөгжөөн цэнгүүлэх, хүү охины талынхан харилцан сонжиж, бие биед нь таниулах, гэр бүл бологсдын ирээдүйн сайн сайхныг бэлгэддэг байсан. Уламжлалт хуримын зан үйлд эдгээр атаа маргаан нь тус тусын гүйцэтгэх дараалал, бэлгэдэлтэй. Хуримын арьс татах атаа нь бэрийг мөргөх ёслол үйлдэхэд дэвссэн хонины арьсыг хоёр талаас тусгайлан бэлдсэн нэг, нэг бяр чадалтай хүн татах ба хүү талын хүн гэрийн дотор, охин талын хүн гэрийн гадна сууж арьсны хүзүү талыг дотогш харуулан татах атаа болно. Хүүгийн тал дийлбэл сайн гэдэг. Энэ нь нэг талаар өрх гэрийн эзэн эр хүний байр суурийг илтгэх, нөгөө талаар хонины ноос үс өсөж, үржихийн (шинэ бэрийн үр хүүхэдтэй болохын) бэлгэдэл болдогтой холбоотой. Гэтэл энэхүү баримтат кинонд арьс татах атааг гэрийн хананы нүдээр гаргаж хоёр талын хүн татах, мөн хүүгийн эцгийн гэрт үйлддэг бол хүүгийн гэрт үйлдэж, хонины арьсны оронд ямааны арьс татаж байна. Мөн уламжлалт хуримд шар нар, шагайт чөмгөнд мөргөсний дараа малгай уралдуулах атаа хийдэг. Хүү, охин хоёрын малгайг шинэ гэрийн үүдээр дотогш нь шидээд, хойноос нь хоёр хүн уралдан орж малгайг авчирдаг. Энэхүү баримтат кинонд хоёр талаас нэг, нэг хүн оролцож байгаагаар гарч байна. Хэний малгайг авсан тухай, мөн яагаад малгайнууд нь дээшээ харж унасан тухай тайлбар хэлээгүй учир бүрэн гүйцэт ойлголтыг өгсөнгүй. Хэрвээ шидсэн малгай ам дээшээ харсан бол сайн хэмээн бэлгэшээж, доошоо харсан бол муу, энэ хоёр заяагаа олохгүй гэж мэргэ төлөгний утгатай үздэг байжээ. Баримтат кинонд гарч буй атаа маргааны утга, бэлгэдлийг дуун тайлбараар хэлсэн бол үзэгчид илүү ойлгож уламжлан хадгалагдах боломж нэмэгдэх байсан болов уу.

### Дүгнэлт

“Алтан тулга, мөнгөн тотго” баримтат киноны хоёрдугаар ангид захчины уламжлалт хуримын үеийн зан үйлийг дүржүүлжээ. Киноны хоёр ангид тусгагдсан зан үйл, ёслолын тайлбар нь судлаач Г.Мэнэсийн захчины хуримын ёс заншлын талаарх судалгаанд голлон тулгуурласан нь агуулгын сонголт, дараалал, нэршлээс тодорхой ажиглагдана. Тухайлбал, хуримын бэлтгэл, хуримын мэдээ, үүдэн дарлага, идээ бараалхуулах, шагайт чөмөг, хүргэнд бүс бүслүүлэх, бэр мордуулах, бэр буулгах, сэв нийлүүлэх, шинэ гэрийн хурим, атаа маргаан, хөшиг тайлах зэрэг ёслолуудыг Г.Мэнэсийн судалгаанд үндэслэн тайлбарласан нь уг киног эрдэм шинжилгээний суурьтай бүтээл болгох давуу тал болжээ. Өмнөх ангитай харьцуулахад хоёрдугаар ангид ёслол, зан үйлийн тайлбарыг дуун тайлбараар илүү дэлгэрүүлж өгсөн нь онцлог байна. Баримтат кинонд буулгаагүй зарим зан үйлийг дуун тайлбараар өгсөн нь баримтат киноны мэдээллийн үнэ цэнийг нэмэгдүүлж, үзэгчдэд зан үйлийн ерөнхий бүтэц, утга учрыг ойлгуулахад чухал ач холбогдолтой байв.

Хуримын үеэр хэлдэг ерөөл нь тухайн ёслолын бэлгэдэл, зорилгыг тодотгон илэрхийлдэг чухал аман уламжлал юм. Баримтат кинонд багтсан ерөөлүүд нь агуулгын хувьд сонирхол татахуйц бөгөөд зан үйлийн утга санааг тодруулах үүрэг гүйцэтгэж байна. Түүнчлэн хурим найрын үеэр заавал дуулдаг, тодорхой журмыг баримталсан дуу байдаг. Гэвч кинонд хүүгийн талаас бэрийн эхэд зориулан “эхийн цагаан сүүний харамж”-ийг магтан дуулдаг “Цагаан цоохор морь” дууг тодорхой дурдсанаас бусад ёслол бүрд эгшиглэж буй дууны нэр, зориулалтын тайлбарыг өгөлгүй орхисон нь бүтээлийг бүрэн дүүрэн ойлгож, хүртээмжтэй байлгахад саад болж байна. Хэрэв дуулж буй дуу бүрийн нэрийг дэлгэцэд бичгээр тэмдэглэсэн бол үзэгчийн ойлголт илүү нэмэгдэх боломжтой байжээ. Захчины хурим найрын дуу, түүний үгийг тэмдэглэн судалсан бүтээлүүд цөөнгүй боловч уг баримтат кинонд эгшиглэж буй дуу бүрийг нэг бүрчлэн сонсож, судалгааны эх сурвалжтай тулган тэмдэглэх нь энэ удаад боломжгүй байв.

Зарим зан үйлийн орон зайн байрлал, дараалал өөрчлөгдсөн нь баримтат кино бүтээх явц дахь монтаж, найруулгын онцлогтой холбоотой байх магадлалтай. Аливаа соёлын биет бус өвийг баримтжуулахад өмнөх судлаачдын судалгааны бүтээл, зан үйлийн дараалал, бэлгэдлийг тодорхой хэмжээнд харгалзан үзэх шаардлагатай. “Алтан тулга, мөнгөн тотго” баримтат кино нь захчины хуримын зан үйлийн баримтат эх сурвалж болохын зэрэгцээ соёлын биет бус өвийн түүхэн хөгжил, хувьсал өөрчлөлтийг олон талт өнцгөөс тайлбарлах судалгааны нэгэн чухал хэрэглэгдэхүүн болох боломжтой бүтээл юм.

#### Ашигласан материалын жагсаалт

- Баасандорж, Ц., Очир, А. 2019. *Ойрад Монголчуудын хуримын ёс*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Баасанжав, Н., Амгалан, Б. 2021. *Захчин аман аялгууны толь*. Улаанбаатар: Голден Легион ХХК.
- Баасанхүү А., Батмөнх Б., 2010. *Монголын ойрадуудын соёл*. Улаанбаатар: Ган принт.
- Монгол судлалын үндэсний зөвлөл. 2023. *Хандын Нямбуу эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. Боть V. Монгол ёс заншлын тайлбар толь*. Эрх. Тамир Ч., Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Мэнэс, Г. 1996. “Захчин: XIX-XX зууны зааг үе дэх Захчины угсаа гарал, засаг захиргаа, овгийн бүрэлдэхүүн.” *Монгол улсын угсаатны зүй II боть*. Ред. Бадамхатан С, 334-377. Улаанбаатар: Сүхбаатар.
- Отгонбаяр, Чулуунмөнх. 2024. “Баримтат кино соёлын өвийг хадгалж, хамгаалах хэрэгсэл болох нь (Телекино үйлдвэрийн баримтат киноны сан хөмрөгийн жишээн дээр).” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Сампилдэндэв, Хорлоо. 1985. *Малчин ардын зан үйлийн уламжлал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

- Туулцэцэг, Ч., Маралмаа, Н. 2023. “Баруун Монголчуудын хуримын зан үйл.”  
*Баруун Монголчуудын аж ахуй, соёлын зарим асуудал*. Ред. Чулуун С, 102-116.  
Улаанбаатар: Адмон принт ХХК.
- Цолоо, Ж. 1988. *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг II боть  
Ойрд аялгуу*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Цэрэнханд, Гэлэгжамц. 2005. *Монголчууд: угсаа-соёл зан заншил II*. Улаанбаатар:  
Адмон принт ХХК.
- ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Кембриджийн их сургууль Монгол ба дотоод  
ази судлалын төв. 2011. *Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх  
хэрэглэгдэхүүн (1977-1978)*. Боть IV. Эрх. Чулуун С., Улаанбаатар: Соёмбо  
принтинг.
- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. 1997. *Монголчуудын хуримлах ёс*. Эмх.  
Сампилдэндэв Х., Улаанбаатар: Эрдэм.
- Эрдэнэцэцэг, Шинэн. 2015. *Баяд хуримын зан үйлийн бэлгэдэл*. Улаанбаатар: Бемби  
сан.
- Юндэнбат, Соном-Иш. 2025. *Өв соёл үнэт зүйл*. Улаанбаатар: Адмон принт ХХК.